



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 01


Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.3, 4.11.2 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Захиргааны удирдлагын газрын дарга, доктор (Ph.D) Балжиннямын Түмэндэлгэрийг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс тус их сургуулийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилон ажиллуулсугай.

2. Хурлын зохион байгуулалт, бэлтгэл үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Түмэндэлгэр)-д даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТУЛГА

367010002



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот


Элсэлтийн хяналтын тоо батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.11.2 дах заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2025-2026 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуульд элсүүлэх бакалавр оюутны элсэлтийн хяналтын тоог хавсралтаар баталсугай.

2. Элсэлтийн үйл ажиллагааг элсэлтийн хяналтын тоонд багтаан, зохих журмын дагуу зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т даалгасугай.

ДАРГА Д.ГАНТУЛГА



367010004

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20... оны дугаар сарын
09 -ний өдрийн дугаар тогтоолын хавсралт



**ШУТИС-ИЙН БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ 2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ХЯНАЛТЫН ТОО**

Д/д	Индекс	Элсэлт авах хөтөлбөрийн нэр	Тэргүүлэх, Эрэлтэй	Элсэлтийн хяналтын тоо (2025 - 2026)		
				Үндсэн	30+(3)	Нийт
1	2	3	4	5	6	7
БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ						
1	073104	Архитектур	Т	60		60
2	073204	Барилгын инженерчлэл	Т	200		200
3	073204	Барилгын инженерчлэл (Японы Нагаока технологийн ИС тай хамтарсан 2.5+2)		10		10
4	073209	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	Т	60		60
5	073207	Усны барилга, байгууламж	Т	60		60
6	073210	Авто замын инженерчлэл	Т	60		60
7	071205	Хаягдал боловсруулах технологи	Т	30		30
8	073201	Усан хангамж, ариутгах татуургын инженерчлэл	Т	60		60
9	073202	Сантехникийн инженерчлэл	Э	60		60
10	073203	Халаалт, агаар сэлгэлт, кондиционер	Э	60		60
11	078808	Усны нөөц, усжуулалт	Т	30		30
12	073107	Хот ба бүс нутгийн төлөвлөлт	Т	30		30
13	073205	Гүүрийн инженерчлэл	Э	30		30
Нийт				750	0	750
ГАДААД ХЭЛНИЙ СУРГУУЛЬ						
14	023101	Гадаад хэлний орчуулга (англи хэл)		30		30
15	023101	Гадаад хэлний орчуулга (хятад хэл)		30		30
16	023101	Гадаад хэлний орчуулга (солонгос хэл)		30		30
17	023101	Гадаад хэлний орчуулга (япон хэл)		30		30
Нийт				120	0	120
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ						
18	072405	Өрөмдлөгийн инженерчлэл		25		25
19	072406	Газрын тосны инженерчлэл	Т	30	10	40
20	072407	Газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл		30		30
21	053201	Геодези	Т	40	5	45
22	053201	Геодези (БНХАУ-ын Шандуны Шинжлэх ухаан технологийн ИС-тай хамтарсан 2+2)		30		30
23	073101	Газар зохион байгуулалт		25		25
24	053204	Геологи	Т	40		40
25	053205	Гидрогеологи		30		30
26	053207	Геофизик		30		30

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20... оны ... дугаар сарын
01... -ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



1	2	3	4	5	6	7
27	053209	Ашигт малтмалын эрэл, хайгуул		30		30
28	072401	Уул уурхайн ашиглалтын технологи	T	90		90
29	072401	Уул уурхайн ашиглалтын технологи (ХБНГУ-ын "Фрайбергийн уул уурхайн академи" техникийн ИС-тай хамтарсан 3+2)		30		30
30	072402	Уул уурхайн геотехник		40		40
31	072403	Уул уурхайн маркшейдер		40		40
32	072404	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	T	30	15	45
33	072901	Уурхайн машин тоног төхөөрөмж		30	15	45
34	072902	Уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт		30	15	45
35	102201	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Э	40	20	60
36	058802	Инженер геологи, геотехник		30		30
37	072408	Хийн инженерчлэл	T	25		25
Нийт				695	80	775
МЕНЕЖМЕНТИЙН СУРГУУЛЬ						
38	041201	Санхүү, банк		60		60
39	041301	Бизнесийн удирдлага		60		60
40	041301	Бизнесийн удирдлага (БНСУ-ын Сөүлийн Шинжлэх ухаан технологийн үндэсний ИС-тай хамтарсан 2+2)		30		30
41	041304	Хүний нөөцийн менежмент		60		60
42	041401	Маркетинг		60		60
43	041305	Нийтийн удирдлага		30		30
44	041302	Үйлдвэрлэлийн менежмент		30		30
45	041303	Менежмент		30		30
46	041601	Худалдаа		30		30
47	048802	Бизнес шинжлэл, загварчлал		30		30
Нийт				420	0	420
МЕХАНИК ИНЖЕНЕР, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ						
48	071502	Металлурги, металлын технологи	T	30		30
49	071507	Машин үйлдвэрлэлийн технологи		30		30
50	071402	Үйлдвэрлэлийн автоматжуулалт	T	30		30
51	071506	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт		30		30
52	073211	Барилга замын машин төхөөрөмж		60		60
53	071501	Механик инженерчлэл	T	120		120
54	071501	Механик инженерчлэл (БНСУ-ын Сүн чон хян ИС-тай хамтарсан 2+2)		30		30
55	071501	Механик инженерчлэл (БНСУ-ын Ханбатын үндэсний ИС-тай хамтарсан 2+2)		30		30
56	071501	Механик инженерчлэл (БНСУ-ын Сөүлийн Шинжлэх ухаан технологийн үндэсний ИС-тай хамтарсан 2+2)		30		30
57	071501	Механик инженерчлэл (Японы Нагаока технологийн ИС-тай хамтарсан 2.5+2)		30		30

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20... оны ... дугаар сарын
09... -ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



1	2	3	4	5	6	7
58	071602	Машины электрон систем		30		30
59	078811	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтын технологи (БНСУ.Гунжугийн үндэсний ИС-тай хамтарсан 3+1)		30		30
60	078811	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтын технологи	Э	30		30
61	041308	Нийлүүлэлтийн сүлжээ, логистик	Т	60		60
62	071601	Авто инженерчлэл		60		60
63	071603	Авто хөдөлгүүрийн механик инженерчлэл		30		30
64	071604	Нисэх техникийн механик	Т	60		60
65	071605	Авионик	Т	30		30
66	071606	Зүтгүүр, зүтгүүрийн аж ахуй		30		30
67	104103	Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалт		30		30
Нийт				810	0	810
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ						
68	061301	Компьютерын ухаан	Т	50	5	55
69	061902	Хиймэл оюун ухаан	Т	50	5	55
70	071405	Программ хангамжийн инженерчлэл	Т	100	10	110
71	061201	Компьютерын сүлжээ		50		50
72	061202	Кибер аюулгүй байдал	Т	80	10	90
73	061202	Кибер аюулгүй байдал (БНСУ-ын Сүн чон хян ИС-тай хамтарсан 2+2)		40		40
74	061204	Өгөгдлийн ухаан	Т	60	5	65
75	061303	Мэдээллийн систем		50	5	55
76	061304	Мэдээллийн технологи	Т	95	5	100
77	071401	Электроникийн инженерчлэл	Т	80	5	85
78	061203	Мультимедиа технологи		50	5	55
79	061901	IoT /Юмсын интернэт/ технологи	Э	50	5	55
80	071407	Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл		55		55
81	071407	Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл (ОХУ-ын Мэдээлэл холбооны техникийн ИС-тай хамтарсан 2+2)		10		10
82	071408	Утасгүй холбооны инженерчлэл	Т	55	5	60
83	071408	Утасгүй холбооны инженерчлэл (ОХУ-ын Мэдээлэл холбооны техникийн ИС-тай хамтарсан 2+2)		10		10
84	078806	Робот ба хиймэл оюун ухаан		50		50
Нийт				935	65	1000
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ						
85	031301	Сэтгэл судлал	Э	80		80
86	041402	Олон нийттэй харилцах ажил		30		30
87	092301	Нийгмийн ажил	Э	50		50
88	101501	Аялал жуулчлал	Э	80		80
Нийт				240	0	240

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20... оны... дугаар сарын
...-ний өдрийн... дугаар тогтоолын хавсралт



1	2	3	4	5	6	7
ХҮНС, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ, ДИЗАЙНЫ СУРГУУЛЬ						
89	051102	Микробиологи		20		20
90	051202	Биотехнологи	Т	20		20
91	072102	Хоол зүй, шим судлал	Э	20		20
92	072103	Хүнсний чанар, аюулгүй байдал	Т	20		20
93	021105	График дизайн		50		50
94	021106	Анимейшн, мультимедиа дизайн	Э	60		60
95	021202	Хувцасны дизайн		30		30
96	021203	Үйлдвэрлэлийн дизайн	Э	30		30
97	021204	Интерьер дизайн		60		60
98	072304	Текстилийн инженерчлэл		20		20
99	082102	Ойн инженерчлэл		20		20
100	071508	Хүнсний үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж		20		20
101	071509	Хөнгөн үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж		20		20
102	072104	Хүнс үйлдвэрлэлийн технологи	Э	35		35
103	072105	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи		25		25
104	072301	Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт	Т	20		20
105	072302	Арьс боловсруулалт, үйлдвэрлэлийн технологи	Т	20		20
106	072203	Хэвлэл, медиа үйлдвэрлэлийн технологи		20		20
107	072204	Мод боловсруулах үйлдвэрлэлийн технологи		20		20
Нийт				530	0	530
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ						
108	054201	Статистик	Т	25		25
109	054201	Статистик (Герман хэлний сургалттай хөтөлбөр)		20		20
110	054201	Статистик (БНХАУ-ын Баруун Хойд Политехникийн ИС-тай хамтарсан 2+2)		20		20
111	053303	Хэрэглээний физик	Т	25		25
112	071201	Хүрээлэн буй орчны инженерчлэл	Т	20		20
113	071201	Хүрээлэн буй орчны инженерчлэл (БНХАУ-ын Нанжины аж үйлдвэрийн ИС-тай хамтарсан 2+2)		20		20
114	078801	Нано шинжлэх ухаан, инженерчлэл	Т	25		25
115	071101	Химийн инженерчлэл	Т	30		30
116	071101	Химийн инженерчлэл (БНХАУ-ын Баруун Хойд Политехникийн ИС-тай хамтарсан 2+2)		25		25
117	071103	Химийн боловсруулалтын технологи		20		20
118	071104	Нүүрсний боловсруулалтын технологи	Т	20		20
119	071105	Газрын тосны боловсруулалтын технологи	Т	20		20
120	072201	Материал судлал, инженерчлэл	Т	25		25
Нийт				295	0	295



1	2	3	4	5	6	7
ЭРЧИМ ХҮЧНИЙ ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ						
121	071301	Сэргээгдэх эрчим хүч	I	90		90
122	071301	Сэргээгдэх эрчим хүч (БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний ИС-тай хамтарсан 2+2)		30		30
123	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл		60		60
124	071305	Дулааны процессын автоматжуулалт		30		30
125	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл (БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний ИС-тай хамтарсан 2+2)		30		30
126	071306	Дулаан хангамжийн инженерчлэл		60		60
127	071308	Хөргөлтийн технологи ба кондиционерийн систем		30		30
128	071304	Цахилгаан системийн автоматжуулалт		100		100
129	078810	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт	T	60		60
130	078810	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт (БНХАУ-ын Шанхайн Шинжлэх ухаан технологийн ИС-тай хамтарсан 2+2)		40		40
131	071309	Цахилгааны инженерчлэл	T	100		100
132	071310	Цахилгаан хангамж	T	90		90
133	071310	Цахилгаан хангамж (БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний ИС-тай хамтарсан 2+2)		30		30
134	078813	Цахилгаан электроник		30		30
Нийт				780	0	780
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ						
135	041301	Бизнесийн удирдлага (ДаТС)		20		20
136	041303	Менежмент (ДаТС)		20		20
137	071502	Металлурги, металлын технологи (ДаТС)	T	15		15
138	071507	Машин үйлдвэрлэлийн технологи (ДаТС)		15		15
139	071506	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт (ДаТС)		15		15
140	072103	Хүнсний чанар, аюулгүй байдал (ДаТС)	T	15		15
141	072104	Хүнс үйлдвэрлэлийн технологи (ДаТС)	Э	15		15
142	072401	Уул уурхайн ашиглалтын технологи (ДаТС)	T	40		40
143	073204	Барилгын инженерчлэл (ДаТС)	T	40		40
144	073201	Усан хангамж, ариутгах татуургын инженерчлэл (ДаТС)	T	15		15
145	073203	Халаалт, агаар сэлгэлт, кондиционер (ДаТС)	Э	15		15
146	073209	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи (ДаТС)	T	20		20
147	071303	Дулааны цахилгаан станцын инженерчлэл (ДаТС)		30		30
148	071309	Цахилгааны инженерчлэл (ДаТС)	T	30		30
149	071405	Программ хангамжийн инженерчлэл (ДаТС)	T	50		50
150	071304	Цахилгаан системийн автоматжуулалт (ДаТС)		30		30
151	072902	Уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт (ДаТС)		15		15

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20... оны ... дугаар сарын
...-ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт



1	2	3	4	5	6	7
152	061202	Кибер аюулгүй байдал (ДаТС 2+2)	Т	30		30
153	061303	Мэдээллийн систем (ДаТС 2+2)		20		20
154	071310	Цахилгаан хангамж (ДаТС 1+3)	Т	15		15
155	071501	Механик инженерчлэл (ДаТС 1+3)	Т	20		20
156	073210	Авто замын инженерчлэл (ДаТС 1+3)	Т	15		15
Нийт				500	0	500
МЕХАНИК ИНЖЕНЕР, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ						
157	071606	Метроны удирдлага, хяналтын инженерчлэл		50		50
158	071501	Метроны механик ба хөдлөх бүрэлдэхүүний инженерчлэл		50		50
159	073204	Метроны барилгын инженерчлэл		50		50
160	071408	Метроны дохиолол ба цахилгааны инженерчлэл		50		50
161	071512	Гагнуурын технологи		30		30
162	071505	Мехатроник		30		30
Нийт				260	0	260
МЕНЕЖМЕНТИЙН СУРГУУЛЬ						
163	041602	Олон улсын бизнес		30		30
Нийт				30	0	30
ЭРЧИМ ХҮЧНИЙ ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ						
164	071305	Дулааны процессын автоматжуулалт (БНХАУ-ын Хойд Хятадын эрчим хүчний ИС-тай хамтарсан 2+2)		30		30
Нийт				30	0	30
Нийт дүн				6395	145	6540

-- оОо --



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Оюутны байрны төлбөр тогтоох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, Төсвийн тухай хуулийн 6.2.3, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журмын 10.8, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.4, 4.11.2, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2025-2026 оны хичээлийн жилд мөрдөх Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн оюутны дотуур байрны төлбөрийг нэгдүгээр хавсралтаар, оюутны байранд амьдардаг айл өрхийн төлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Оюутны дотуур байруудад засвар, тохижилтын ажил хийж, орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т үүрэг болгосугай.

3. Оюутны дотуур байруудын орчин нөхцөлийг сайжруулахтай холбогдон гарах зардлыг 2025 оны төсвийн тодотголын төсөлд тусган, хөрөнгө оруулалт, худалдан авалт, урсгал засварын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т зөвшөөрсүгэй.



ДАРГА

Д.ГАНТУЛГА

367010006

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20..... оны дугаар сарын
 09 нийсдрийн дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ
 ОЮУТНЫ БАЙРНЫ ТӨЛБӨР

Оюутны байр	Төрөл	Багтаамж	Сарын төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)	
			Нэг оюутан	Оюутнаас авах барьцаа (жилд)
Оюутны I байр (ХШУС)	оюутан	4 хүний	91,900	30,000
	оюутан	1 хүний	294,300	30,000
	гадаад оюутан, мэргэжилтэн	2 хүний хагас люкс	273,100	30,000
	гадаад оюутан, мэргэжилтэн	2 хүний энгийн	252,400	30,000
Оюутны III байр (НХС)	оюутан	2 хүний	197,000	30,000
	оюутан	4 хүний	167,000	30,000
	гадаад оюутан	2 хүний	252,400	30,000
Оюутны IV байр (МХТС)	оюутан	4 хүний	91,900	30,000
Оюутны V байр (МИТС)	оюутан	4 хүний	91,900	30,000
ДаТС	оюутан	2 хүний	106,900	30,000
	оюутан	4 хүний	91,900	30,000

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20²⁵ оны ⁰⁵ дугаар сарын
⁰⁹ ний өдрийн ⁰³ дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ
ОЮУТНЫ БАЙРАЙД АМЬДАРДАГ АЙЛ, ӨРХИЙН ТОЛБОР

Оюутны байр	Өрөөний багтаамж м.кв	Нэг өрхийн сарын төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)				
		түрээс	цахилгаан	дулаан, халуун ус, цэвэр бохир ус	хог	нийт төлбөр
Оюутны III байр (НХС)	12 м.кв	187,000	25,900	36,900	2,200	251,900
	18 м.кв	228,300	28,600	40,700	2,400	300,000
Оюутны IV байр (МХТС)	18 м.кв	132,000	25,900	36,900	2,200	196,900
	36 м.кв	206,800	25,900	36,900	2,200	271,700
Оюутны V байр (МИТС)	9 м.кв	118,800	25,900	36,900	2,200	183,700
	12 м.кв	187,000	25,900	36,900	2,200	251,900
	18 м.кв	206,800	25,900	36,900	2,200	271,700
	24 м.кв	264,000	25,900	36,900	2,200	328,900

-- оОо --



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 04


Улаанбаатар хот

“ШУТИС-ийн Эндаументын сангийн журам” батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/331 дүгээр тушаалаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам", Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.3, 4.11.2, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэл, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрдмийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоол, Ректорын зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эндаументын сангийн журам”-ыг хавсралтаар баталж, 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эндаументын сангийн журам”-ын хэрэгжилтийг хангаж, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, өсгөх, зарцуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т даалгасугай.



367010008

	ШУТИС-ийн Эндаументын (endowment) сангийн журам ШУТИС-ЭШ-ЖУ08	Охний хэвлэлт	2025.05.20
		Өөрчилсөн огноо	-
		Өөрчлөлтийн дугаар	-

ШУТИС-ИЙН ЭНДАУМЕНТЫН САНГИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар нь Боловсролын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.23-д заасан ШУТИС-ийн Эндаументын сангийн мөнгөн орлого, хөрөнгө бүрдүүлэх, хөрөнгийг өсгөх болон зарцуулах менежмент, тайлан, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2 ШУТИС-ийн Эндаументын сан (цаашид “сан” гэх)-гийн журмын зорилго нь хандивлагч, хөрөнгө оруулагчдаас өгсөн хөрөнгийг хүлээн авах, бүртгэх, сангийн хөрөнгийг хадгалах, зарцуулах, өсгөх замаар их сургуулийн урт хугацааны санхүүгийн тогтвортой байдал болон хөгжлийн стратеги, судалгаа, инновацын зорилтот хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд оршино.
- 1.3 ШУТИС-ийн Эндаументын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
 - 1.3.1 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бэлэглэсэн, шилжүүлсэн, өв залгамжлуулсан мөнгөн хөрөнгө, үнэт цаас;
 - 1.3.2 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шилжүүлсэн аливаа үл хөдлөх хөрөнгө болон түүнтэй адилтгах бусад хөрөнгө;
 - 1.3.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн лабораторийн тоног төхөөрөмж, машин механизм, багаж хэрэгсэл, урвалж бодис;
 - 1.3.4 Хүүгийн болон ноогдол ашиг, түрээсийн орлого;
 - 1.3.5 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад хандив, орлого;
 - 1.3.6 Их сургуулийн профессор, багш нар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтээсээ өөрийн санаачилгаар өгсөн мөнгөн хандив;
- 1.4 ШУТИС-ийн Эндаументын сан нь ашгийн бус сан байх ба хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол сангийн хөрөнгийг уг журамд заасан тогтоосон хязгаарын хүрээнд захиран зарцуулах эрхтэй эндаументын сан хэлбэртэй байна.
- 1.5 Хэрэв хандивлагч өөрийн оруулсан хөрөнгийг хязгаарлалттай, хугацаатай хэлбэрээр зарцуулахыг санал болгосон тохиолдолд хандивлагчтай тусгайлсан гэрээ байгуулж, тухайн хандивлагчийн санал болгосон хэлбэрээр хэсэгчилсэн үйл ажиллагаа явуулж болно.
- 1.6 Энэ журмаар зохицуулагдаагүй харилцааг сургуулийн Удирдах зөвлөл холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухай бүр шийдвэрлэнэ.

ХОЁР. САНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1 ШУТИС-ийн эндаументын сан нь үндсэн хөрөнгийг хадгалж, өсгөх замаар тогтвортой орлогыг бий болгож, их сургуулийн стратегийн зорилтыг хангахуйц үйл ажиллагаанд зарцуулахад чиглэнэ.
- 2.2 Эндаументын сангийн хөрөнгийг ШУТИС-ийн санхүүгийн нэгжийг түшиглэн арилжааны банкинд тусдаа данс нээж, тайлан тооцоог Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүртгэж, хэрэгжүүлнэ.
- 2.3 Эндаументын сангийн эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгийг өсгөх, зарцуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ажлыг санхүүгийн мэдлэг, чадвар, туршлагатай гишүүдээс бүрдсэн Эндаументын сангийн зөвлөл хариуцах ба



зөвлөлийн гишүүдийг ШУТИС-ийн Ректорын тушаалаар томилно. Зөвлөлийн гишүүнд хандивлагч, эсвэл түүний төлөөллийг сонгож болно.

- 2.4 Эндаументын сангийн зөвлөл нь сангийн хөрөнгө оруулалтын стратеги, хөрөнгийн хуваарилалт, сангийн зорилтууд болон зах зээлийн нөхцөл байдлаас хамааран эрсдэлийн түвшинг тодорхойлж, сангийн үйл ажиллагаа, менежментийг хариуцна.
- 2.5 Эндаументын сангийн хөрөнгө оруулалт нь их сургуулийн үнэт зүйлст нийцэх, тэр дундаа тогтвортой байдал болон нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт хийх зарчимд тулгуурласан байна.
- 2.6 Энэхүү журам болон сангийн зөвлөлийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүргийг их сургуулийн Ректор хариуцна.
- 2.7 Эндаументын сангийн зохион байгуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг сургуулийн Удирдах зөвлөл баталж, сангийн гүйцэтгэл, бодлогын хэрэгжилтийг Эндаументын сангийн зөвлөл хариуцна.
- 2.8 Эндаументын сангийн гүйцэтгэх удирдлагыг сургуулийн Удирдах зөвлөл томилно. Гүйцэтгэх удирдлага нь сангийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн удирдана.
- 2.9 Сангийн зөвлөлийн дарга сангийн гүйцэтгэх удирдлага байна.

ГУРАВ. САНГИЙН ХӨРӨНГӨ БҮРТГЭХ, ӨСГӨХ

- 3.1 Эндаументын сангийн хөрөнгийг хүлээн авах, бүртгэх ажлыг их сургуулийн санхүүгийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлэх бөгөөд орлогыг санхүүгийн тайлан тэнцэлд тусгана.
- 3.2 Санд хандивлагч, хөрөнгө оруулагчдаас өгсөн хөрөнгийг хүлээн авсан тухай баримтыг 2 хувь үйлдэж, хандивлагч талд нэг хувийг албан ёсоор хүлээлгэн өгнө. Баримтад орлогын тодорхой зорилго, чиглэлийг тусгана.
- 3.3 Санд хөрөнгө хандивласан тохиолдолд холбогдох бичиг баримтын хамт их сургуулийн санхүүгийн нэгж хүлээн авч, сангийн хөрөнгөд бүртгэнэ.
- 3.4 Бараа материал болон үндсэн хөрөнгийг эндаументын сангийн дансны орлогод авах эсвэл ШУТИС-ийн шаардлагатай нэгжид шилжүүлэх тухай асуудлыг Сангийн зөвлөл Удирдах Зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 3.5 Эндаументын санд шууд бусаар хандив, хөрөнгө оруулалт (*ирээдүйд олгох хадгаламжийн хүү, тэтгэлэг гэх мэт*) оруулах асуудлыг хандивлагчтай тусгайлсан гэрээ байгуулж зохицуулна.
- 3.6 Засгийн газар, нийслэлийн бонд, нэр хүнд бүхий компанийн бонд, хувьцаа худалдан авах, арилжааны банканд хадгаламжийн сертификат, хадгаламжийн дансанд байршуулах хүүгийн болон ногдол ашиг авах замаар сангийн хөрөнгийг холбогдох хуулийн хүрээнд өсгөж болно.
- 3.7 Энэхүү журмын 1.3.1-т заасан эх үүсвэрээс мөнгөн хандив эндаументын санд төвлөрүүлсэн ШУТИС-ийн багш, ажилтанд сангийн зөвлөлийн шийдвэрээр тухайн хандивын орлогоос судалгааны грант, тэтгэлэг олгож болно.
- 3.8 Эндаументын санд хөрөнгө оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад их сургуулийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд (сургалт явуулах, судалгаа шинжилгээ хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэх мэт) дэмжлэг үзүүлж болно.
- 3.9 Сангийн зөвлөл нь хандивлагчидтай эргэх холбоотой ажиллаж, шаардлагатай тохиолдолд хандивын зарцуулалт болон үр дүнгийн талаар мэдээлэл өгнө.
- 3.10 Эндаументын сан нь хандив, тусламжаар хүлээн авсан хөрөнгийн хэмжээнээс хамаарч хандивлагчдыг олон нийтэд сурталчлах, анги танхим, лабораторийг хандивлагчийн нэрэмжит болгож алдаршуулах ажлыг зохион байгуулж болно.



ДӨРӨВ. САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ

- 4.1 Сангийн орлого, хөрөнгийг их сургуулийн хөгжил, судалгаа, инновацын зорилтот дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.
 - 4.1.1 Сургуулийн урт хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулагчтай бичгээр зөвшилцөн сургуулийн дэд бүтцийг хөгжүүлэх арга хэмжээ;
 - 4.1.2 Хандивлагчийн нэрэмжит сургалтын тэтгэлгийг өөрийн сургуулийн суралцагчдад олгох;
 - 4.1.3 Нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий тодорхой асуудал шийдвэрлэхэд чиглэсэн судалгааны төсөл, хөтөлбөр;
 - 4.1.4 Их сургуулийн оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааны санхүүжилт;
 - 4.1.5 Судалгаа, инновацын үйл ажиллагаа, гарааны бизнес хөгжүүлэх санхүүжилт;
- 4.2 Сангийн хөрөнгийн нэг жилийн зарцуулалт нь сангийн хөрөнгийн тухайн жилийн өссөн дүнгээс орсон орлогын 90 хувиас хэтрэхгүй байна. Сангийн хөрөнгийн тодорхой хувийг нөөц үүсгэн төвлөрүүлж, өсгөнө.
- 4.3 Сангийн хөрөнгө, орлогыг журмын 4.1-т зааснаас бусад зориулалтаар зарцуулах, ашиглах, худалдан борлуулах, бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 4.4 Сангийн хөрөнгө, орлогыг сургуулийн удирдах албан тушаалтнуудыг урамшуулахад зарцуулахыг хориглоно.
- 4.5 Сангийн хөрөнгийг зарцуулах жилийн төсөвт удирдлага менежментийн болон үйл ажиллагааны зорилтот арга хэмжээнд зарцуулах зардлын хязгаарыг тогтооно.

ТАВ. САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ

- 5.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу сангийн тайлан, мэдээг тайлан хариуцсан нягтлан бодогч боловсруулж, сургуулийн шилэн дансанд тогтмол оруулж ажиллана.
- 5.2 Эндаументын сангийн удирдлагын ил тод байдлыг хангахын тулд хагас жил тутам тайланг хандивлагч, олон нийтэд үнэн зөв, ойлгомжтой байдлаар сургуулийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.
- 5.3 Сангийн үнэн зөв байдлыг баталгаажуулахын тулд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, үйл ажиллагааны хэрэгжилт, зарцуулалт, нөлөөллийг сургуулийн Эндаументын сангийн зөвлөлд тайлагнана.
- 5.4 Сангийн орлогыг энэ журмын 4.1-т заасны дагуу зарцуулсан эсэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хяналт тавьж, саналаа сургуулийн Удирдах зөвлөлд гаргаж шийдвэрлүүлж болно.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1 Эндаументын санд согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хүн, байгаль орчинд халтай үйл ажиллагаа явуулдаг, мөн шашны гаж урсгал, тулгалт, мөнгө угаах гэмт хэргийн шинж чанартай хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг нь тогтоогдсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хандив, тусламж авахыг хориглоно.
- 6.2 Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, сонирхлын зөрчил бүхий гэрээ, хэлцэл байгуулсан нь нотлогдсон тохиолдолд шийдвэр гаргасан албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20²⁵ оны 05 дугаар
сарын 20-ны өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт



- 6.3 Сангийн зөвлөл нь сангийн үйл ажиллагааг хариуцлагатай удирдан зохион байгуулж, их сургуулийн сургалтын төлбөр болон төрийн санхүүжилтийн хамаарлыг бууруулахад анхаарна.
- 6.4 Энэхүү журмын зарим хэсэг нь дээд эрэмбийн хууль тогтоомжтой зөрчилдсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол тэрхүү хэсгийг хасагдсанд тооцох ба журмын бусад зохицуулалтуудад нөлөөлөхгүй.
- 6.5 “Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам”-д нийцүүлэн энэхүү журмыг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг сургуулийн Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

---o0o---



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, Төсвийн тухай хуулийн 6.2.3, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журмын 10.8, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.11.2, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2025-2026 оны хичээлийн жилд мөрдөх бакалаврын сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг нэгдүгээр хавсралтаар тогтоон мөрдсүгэй.


2. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд явагдах бусад төрлийн сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг хоёрдугаар хавсралтаар тогтоон мөрдсүгэй.

3. 2025-2026 оны хичээлийн жилд шинээр элссэн оюутны мэргэшүүлэх хичээлийн нэг кредитийн үнэлгээг тооцохдоо ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээг 15 хувиар нэмэгдүүлэн тогтоосугай.

4. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд суралцах гадаад оюутны сургалтын нэг кредитийн үнэлгээг тооцохдоо энэхүү тогтоолын нэгдүгээр болон хоёрдугаар хавсралтад заагдсан сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг 1.5 коэффициентоор үржүүлж тогтоосугай.

5. Нэг кредитийн үнэлгээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2025 оны төсөвт нэмэлт өөрчлөлт хийх тодотголын төслийг 2025 оны 11 дугаар сарын 15-ны дотор Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, хэлэлцүүлэхийг ректор (Т.Намнан)-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.



367010010

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20
ны өдрийн 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ШУТИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилд мөрдөх бакалаврын
сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ /төгрөгөөр/

№	Сургууль	2025-2026 оны хичээлийн жилд шинээр элсэгч	2024-2025, 2023-2024 оны оны хичээлийн жилд элссэн оюутан		2022-2023 оны хичээлийн жилд элссэн оюутан		2021-2022 оны хичээлийн жилд элссэн ба түүнээс өмнө элссэн оюутан	
		Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Мэргэшүүлэх хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Мэргэшүүлэх хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн 1 кредитийн үнэлгээ	Мэргэшүүлэх хичээлийн 1 кредитийн үнэлгээ
1	Барилга, архитектурын сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
2	Гадаад хэлний сургууль	185,600.0	148,000.0	170,200.0	141,000.0	162,150.0	108,000.0	124,200.0
3	Геологи, уул уурхайн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
4	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
5	Менежментийн сургууль	185,600.0	166,000.0	190,900.0	157,000.0	180,550.0	120,000.0	138,000.0
6	Механик инженер, тээврийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
8	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	185,600.0	166,000.0	190,900.0	157,000.0	180,550.0	120,000.0	138,000.0
9	Хүнс, хөнгөн, үйлдвэрлэл, дизайны сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
10	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	190,000.0	148,000.0	170,200.0	141,000.0	162,150.0	108,000.0	124,200.0
11	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль	190,000.0	170,000.0	195,500.0	162,000.0	186,300.0	123,000.0	141,450.0
Дундаж		162,812.0						

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20
 ны өдрийн 05 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ШУТИС-ийн 2025-2026 оны хичээлийн жилд явагдах
 бусад төрлийн сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ /төгрөгөөр/

Сургалтын төрөл	Нэг кредитийн үнэлгээ
Бямбын, эчнээ, гарагийн сургалт	Тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн нэг кредитийн үнэлгээг 1.2 коэффициентоор үржүүлж тооцно.
Гадаад хэл дээрх хөтөлбөр, гадаад хэл дээр заагдаж буй хичээл /монгол оюутан/	
Магистрын хөтөлбөр	Тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн нэг кредитийн үнэлгээг 1.4 коэффициентоор үржүүлж тооцно.
Докторын хөтөлбөр	Тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн нэг кредитийн үнэлгээг 1.8 коэффициентоор үржүүлж тооцно.
Ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэнгийн магистрын хөтөлбөр	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн инженер, технологийн бакалаврын хөтөлбөрийн сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.4 коэффициентоор үржүүлж тооцно.
Ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын хүрээлэнгийн докторын хөтөлбөр	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн инженер, технологийн бакалаврын хөтөлбөрийн сургалтын нэг кредитийн үнэлгээг 1.8 коэффициентоор үржүүлж тооцно.